



MEMORANDUM OF UNDERSTANDING BETWEEN TURKISH COURT OF ACCOUNTS AND MONGOLIAN NATIONAL AUDIT OFFICE

The Turkish Court of Accounts and the Mongolian National Audit Office, (hereinafter referred to as "Party" and collectively as "Parties"),

Based on the principles of mutual respect, trust, equality, partnership and cooperation;
Guided by the purposes and fundamental principles of activity of the International Organization of Supreme Audit Institutions (INTOSAI) and the Asian Organization of Supreme Audit Institutions (ASOSAI);

And in conjunction with the mutual aspiration to increase the efficiency of state audits, with full respect for enforced Laws and regulations of their own States and according to their available resources;

Have come to the following understanding:

Article 1. Objective

The objective of the cooperation under this Memorandum of Understanding is to strengthen, promote, and develop a framework for cooperation and efficient interaction between the Parties in the areas of state audits within the framework of INTOSAI, ASOSAI and any other regional organizations of which they are members.

Article 2. Areas and forms of cooperation

The Parties will cooperate in the following areas:

- 1) conduct reciprocal visits with the aim of strengthening the development and future cooperation between the Supreme Audit Institutions of the two countries;
- 2) organize joint training programs, seminars, and meetings for the exchange of experience and best practices in the field of auditing;
- 3) include officials in exchange programs for professional development and the study of best practices;
- 4) exchange experience in the development of technical infrastructure for digital auditing and in the application of advanced systems based on artificial intelligence and data analytics in audit activities;
- 5) subject to mutual agreement and within the scope of their respective mandates and available resources, support projects or programs initiated by either Party;
- 6) by mutual agreement, cooperate in other forms deemed mutually beneficial within the framework of this Memorandum of Understanding.

Article 3.

Financial arrangements

In conducting activities under this Memorandum of Understanding, each Party is expected to bear the costs and expenses of their respective activities according to their available resources.

Article 4.

Communications

The communication between the Parties in the implementation of the activities within this Memorandum of Understanding will be in English.

Article 5.

Confidentiality

1. In the exchange of information and materials under this Memorandum of Understanding, each Party shall be guided by the applicable laws and regulations of their countries related to the exchange of information and the protection of state secrets and other secrets protected by laws and regulations.

2. Each Party undertakes to use the exchanged information and materials received or supplied to the other Party exclusively for the performance of the functions assigned to supreme audit institutions, the preparation of analytical and methodological materials, the professional development of employees, and the development of cooperation in the field of external state audit. Exchanged information and materials may not be provided to third parties without the consent of the other Party.

Article 6.

Protection of intellectual property rights

The Parties acknowledge the importance of protecting and respecting intellectual property rights. Intellectual property rights used or transferred by the Parties in accordance with this Memorandum, or arising from joint work, shall not be transferred by either Party to a third Party without prior written consent.

Within the framework of this Memorandum of Understanding, each Party shall be guided by the current regulatory legal acts of their states in the area of regulation of issues and protection of intellectual property rights.

Article 7.

Settlement of disputes

Any differences or disputes arising from the interpretation and/or implementation of any of the provisions of this Memorandum of Understanding shall be settled by mutual agreement of the Parties through direct consultation and/or negotiation between the two Parties.

Article 8. Amendments

Either Party may request, in writing, an amendment of this Memorandum of Understanding. Such amendment shall be agreed upon in writing by the two Parties, and shall enter into force in accordance with the terms agreed upon between the two Parties.

Article 9. Entry into force, duration and termination


1. This Memorandum of Understanding shall come into effect upon signing by both Parties.

2. This Memorandum of Understanding is concluded for five (5) years and upon expiration of that period shall be automatically renewed each time for similar five-year periods unless either Party notifies the other through diplomatic channels of its intention to terminate it at least six (6) months prior to the proposed date of termination. Nonetheless, each Party shall have the right to terminate this Memorandum of Understanding at any time by giving the relevant written notice to the other Party through diplomatic channels. In this case, this Memorandum shall be terminated six (6) months after the date of receipt of such notification by the other Party.

3. The termination of this Memorandum of Understanding shall not affect the ongoing projects and activities under the Memorandum until their full completion, unless the Parties agree otherwise in a written form.

Signed in Ankara, on 06 February 2026, in duplicate, each in Mongolian, Turkish and English languages, all texts being equally authentic. In case of any divergence in interpretation of the provisions of this Memorandum, the English text shall prevail.

**For the
Turkish Court of Accounts**



Mr. Metin YENER

**For the
Mongolian National Audit Office**



Mr. Magnaisuren SANDAG



**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ТООЦООНЫ ШҮҮХ
ХООРОНДЫН
ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ**

Монгол Улсын Үндэсний аудитын газар болон Бүгд Найрамдах Турк Улсын Тооцооны Шүүх (цаашид “Тал” болон хамтдаа “Талууд” гэж нэрлэх),

Харилцан хүндэтгэл, итгэлцэл, тэгш байдал, түншлэл, хамтын ажиллагааны зарчмуудад тулгуурлан;

Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага (ИНТОСАИ) болон Аудитын дээд байгууллагуудын Азийн байгууллага (АСОСАИ)-ын зорилго, суурь зарчмуудыг удирдлага болгон;

Төрийн аудитын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх нийтлэг эрмэлзэлтэйгээр, талуудын улс орны хүчин төгөлдөр хууль тогтоомж болон нөөц боломжийг хүндэтгэн дор дурдсан ойлголцолд хүрлээ:

**1 дүгээр зүйл
Зорилго**

Энэхүү санамж бичгийн хүрээнд хамтран ажиллах зорилго нь ИНТОСАИ, АСОСАИ болон бусад бүс нутгийн байгууллагуудын хүрээнд талуудын аудитын үйл ажиллагааны чиглэлээр үр нөлөөтэй хамтын ажиллагааг өргөжүүлж, хөгжүүлэхэд оршино.

**2 дугаар зүйл
Хамтын ажиллагааны чиглэл**

Талууд дараах чиглэлээр хамтран ажиллана:

1) Хоёр орны Аудитын дээд байгууллагын хөгжил, цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор харилцан айлчлал хийх;

2) Аудитын үйл ажиллагааны чиглэлээр туршлага солилцох хамтарсан сургалт, семинар, уулзалт зохион байгуулах;

3) Албан хаагчдыг мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах солилцооны хөтөлбөрт хамруулах;

4) Дижитал аудитын техникийн дэд бүтцийг хөгжүүлэх болон хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжилгээнд суурилсан дэвшилтэт системийг аудитын үйл ажиллагаанд ашиглах чиглэлээр харилцан туршлага солилцох;

5) Талууд харилцан тохиролцсоны үндсэнд өөрсдийн бүрэн эрх, нөөц боломжийн хүрээнд аль нэг Талын санаачилсан төсөл, хөтөлбөрийг дэмжиж болно;

6) Талууд тохиролцон харилцан ашигтай гэж үзсэн тохиолдолд энэхүү харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд бусад хэлбэрээр хамтран ажиллаж болно.

3 дугаар зүйл **Санхүүгийн зохицуулалт**

Энэхүү санамж бичгийн хүрээнд зохион байгуулагдах үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг Талууд өөрсдийн боломж, нөөцийн хүрээнд тус тусдаа хариуцна.

4 дүгээр зүйл **Харилцаа холбоо**

Энэхүү санамж бичгийн хүрээнд хэрэгжих үйл ажиллагааны харилцаа холбоо нь англи хэлээр явагдана.

5 дугаар зүйл **Нууцлал**

1. Энэхүү санамж бичгийн хүрээнд мэдээлэл, баримт бичиг солилцоходоо Талууд өөрсдийн улсын олон улсын мэдээлэл солилцох, төрийн болон албаны нууцын тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийг баримтална.

2. Талууд харилцан солилцсон мэдээлэл, баримт бичгийг зөвхөн байгууллагын чиг үүргийн хүрээнд судалгаа, шинжилгээ хийх, арга зүйн баримт бичиг боловсруулах, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ашиглах үүрэг хүлээнэ. Талууд солилцсон мэдээлэл, баримт бичгийг нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.

6 дугаар зүйл **Оюуны өмчийг хамгаалах**

Талууд оюуны өмчийн эрхийг хамгаалж, хүндэтгэнэ. Энэхүү санамж бичгийн хүрээнд Талуудын ашигласан, шилжүүлсэн, эсхүл хамтын ажиллагааны үр дүнд үүссэн оюуны өмчийн эрхийг аль нэг Тал урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

Энэхүү санамж бичгийн хүрээнд Талууд өөрсдийн улсын хүчин төгөлдөр хууль, эрх зүйн актад нийцүүлэн оюуны өмчийн эрхийн зохицуулалт болон хамгаалалтын асуудлыг хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл **Маргаан шийдвэрлэх**

Энэхүү санамж бичгийн аль нэг зүйлийг тайлбарлах, хэрэгжүүлэхтэй холбоотой маргаан, зөрүүг Талууд харилцан зөвшилцөх, шууд хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл **Нэмэлт, өөрчлөлт оруулах**

Талуудын аль нэг нь энэхүү санамж бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг бичгээр гаргаж болно. Ийм нэмэлт, өөрчлөлт нь Талуудын бичгээр харилцан тохиролцсон нөхцөлийн дагуу хүчин төгөлдөр болно.

9 дүгээр зүйл

Хүчин төгөлдөр болох, хугацаа болон дуусгавар болгох

1. Энэхүү санамж бичиг нь хоёр Тал гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү санамж бичиг нь таван (5) жилийн хугацаанд үйлчлэх бөгөөд Талуудын аль нэг нь санамж бичгийг дуусгавар болгох талаар санамж бичгийн хугацаа дуусахаас зургаан (6) сараас өмнө дипломат шугамаар мэдэгдээгүй тохиолдолд дахин таван жилийн хугацаагаар сунгагдах болно.

Аль нэг Тал энэхүү санамж бичгийг ямар ч үед дипломат шугамаар нөгөө Талд бичгээр мэдэгдэн дуусгавар болгох эрхтэй. Энэ тохиолдолд санамж бичиг нь нөгөө Тал мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш зургаан (6) сарын дараа дуусгавар болно.

3. Хэрэв Талууд өөрөөр бичгээр тохиролцоогүй тохиолдолд санамж бичиг дуусгавар болсон ч, хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, шийдвэрлэх шатандаа байгаа эрх, үүрэгт энэхүү санамж бичгийн зохицуулалтууд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

Энэхүү санамж бичгийг 2026 оны 2-р сарын 6-ны өдөр Анкара хотноо монгол, турк, англи хэлээр хоёр хувь үйлдэв. Бүх эх бичвэрүүд адил хүчинтэй бөгөөд ойлголцлын зөрүү гарсан тохиолдолд англи хэлээр үйлдсэн эхийг баримтална.

**Бүгд Найрамдах Турк
Улсын Тооцооны
шүүхийг төлөөлж**



**Метин Йенер
Бүгд Найрамдах Турк Улсын
Тооцооны шүүхийн
Ерөнхийлөгч**

**Монгол Улсын
Үндэсний аудитын
газрыг төлөөлж**



**Сандагийн Магнайсүрэн
Монгол Улсын
Ерөнхий аудитор**